



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/208/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorj@audit.gov.mn
Аудитор: Ц.Мөнхтуяа
Утас: 260512 Цахим хаяг: munkhtuyats@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Си Пи Ти Эй Аудит" ХХК
Захирал: Ч.Энхчимэг
Цахим хаяг: info@cptaaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бала тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26 04-37, Факс:51 26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/410

төхөөрх № _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүүхдийн төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,519,403.00	30,182,776.00
33	АВЛАГА	6,361,403.00	189.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	154,386.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5,699,120.00	-
335	Бусад авлага	507,897.00	189.00
3351	Байгууллагаас авах авлага	615.00	189.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	507,282.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	13,158,000.00	30,182,587.00
351	Түүхий эд материал	6,528,681.00	17,546,083.00
35110	Тусгай зориулалттай материал	6,528,681.00	17,546,083.00
354	Хангамжийн материал	6,629,319.00	12,636,504.00
35410	Бичиг хэргийн материал	4,495,079.00	5,131,034.00
35420	Аж ахуйн материал	768,040.00	6,139,270.00
35470	Бусад хангамжийн материал	1,366,200.00	1,366,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	615,561,166.45	682,693,577.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	615,561,166.45	682,693,577.73
392	Биет хөрөнгө	615,561,166.45	682,693,577.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,000,000.00	21,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,000,000.00)	(21,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	105,018,445.50	142,931,225.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(98,340,099.10)	(102,455,305.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,619,447.82	95,708,247.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(79,557,189.54)	(82,688,449.59)
39217	Ном	598,820,561.77	629,197,859.77
39301	Програм хангамж	4,179,100.00	4,179,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,179,100.00)	(4,179,100.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	635,080,569.45	712,876,353.73
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	635,080,569.45	712,876,353.73
51	Засгийн газрын хувь оролцоо	635,080,569.45	712,876,353.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	398,693,113.63	398,693,113.63
51101	Өмч: - төрийн	398,693,113.63	398,693,113.63
512	Хуримтлагдсан үр дүн	163,742,094.28	241,537,878.56
51210	Өмнөх үеийн үр дүн	163,742,094.28	163,742,094.28
51220	Тайлант үеийн үр дүн	-	77,795,784.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	72,645,361.54	72,645,361.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	635,080,569.45	712,876,353.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	731,673,665.00	730,800,787.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,329,845.00	55,629,287.00
120	Нийтлэг татварын бус орлого	24,329,845.00	55,629,287.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,329,845.00	55,629,287.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,329,845.00	55,629,287.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	707,343,820.00	675,171,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	688,502,200.00	610,662,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	688,502,200.00	610,662,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,841,620.00	64,509,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,292,870.00	24,898,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	30,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,548,750.00	9,110,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	698,055,105.75	653,005,002.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	698,055,105.75	653,005,002.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	622,139,832.99	633,403,700.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	389,966,874.52	371,082,659.00
210101	Үндсэн цалин	389,966,874.52	280,225,758.00
210102	Нэмэгдэл	-	69,507,701.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,349,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,420,041.18	48,959,200.42
210201	Тэтгэврийн даатгал	35,046,221.14	34,507,467.12
210202	Тэтгэмжийн даатгал	4,132,487.77	3,841,930.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,134,629.62	2,955,944.40
210204	Ажилгүйдлийн даатгал	732,719.11	695,806.28
210205	Эрүүл мэндийн даатгал	7,373,983.55	6,958,052.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,047,200.00	137,047,700.00
210304	Байрны түрээс	137,047,200.00	137,047,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,533,323.80	40,922,914.61
210401	Бичиг хэрэг	3,154,071.00	8,934,101.00
210402	Тээвэр, шатахуун	1,852,285.00	525,426.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,614,078.80	5,129,360.61
210404	Ном, хэвлэл	33,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	786,000.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,358,230.00	25,508,328.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	15,735,659.00	165,699.00
2105	Нормативт зардал	1,568,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,568,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,366,750.00	28,144,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,513,850.00	19,931,860.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	95,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,500.00	97,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,660,000.00	5,520,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,237,643.49	7,246,466.72
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,237,643.49	7,246,466.72

Хүүхдийн төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,915,272.76	19,601,301.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,728,565.00	2,667,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	72,628,565.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	2,667,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,186,707.76	16,933,501.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,134,407.76	16,904,546.97
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	52,300.00	28,955.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	33,618,559.25	77,795,784.28
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,831,407.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,831,407.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(5,831,407.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	27,787,152.25	77,795,784.28

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооныний т дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,693,113.63	37,941,094.89	135,954,942.03	572,589,150.55
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	398,693,113.63	37,941,094.89	135,954,942.03	572,589,150.55
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	34,704,266.65	-	34,704,266.65
Тайлант үеийн үр дүн	-	-	27,787,152.25	27,787,152.25
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,693,113.63	72,645,361.54	163,742,094.28	635,080,569.45
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	398,693,113.63	72,645,361.54	163,742,094.28	635,080,569.45
Тайлант үеийн үр дүн	-	-	77,795,784.28	77,795,784.28
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,693,113.63	72,645,361.54	241,537,878.56	712,876,353.73

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	707,343,820.00	680,870,620.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	707,343,820.00	680,870,620.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	688,502,200.00	610,662,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	688,502,200.00	610,662,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,841,620.00	70,208,120.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,292,870.00	30,597,520.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	30,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,548,750.00	9,110,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	686,622,569.00	647,767,029.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	686,622,569.00	647,767,029.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	605,008,176.24	628,165,727.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	390,548,371.74	370,377,391.00
210101	Үндсэн цалин	266,143,629.74	283,175,912.00
210102	Нэмэгдэл	85,071,362.00	67,025,879.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,333,380.00	20,175,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,559,175.70	48,959,200.42
210201	Тэтгэврийн даатгал	35,185,875.70	34,507,467.12
210202	Тэтгэмжийн даатгал	3,843,300.00	3,841,930.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,074,700.00	2,955,943.42
210204	Ажилгүйдлийн даатгал	768,600.00	695,806.28
210205	Эрүүл мэндийн даатгал	7,686,700.00	6,958,053.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,047,200.00	137,047,700.00
210304	Байрны түрээс	137,047,200.00	137,047,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,221,778.80	28,112,150.61
210401	Бичиг хэрэг	2,504,500.00	2,357,070.00
210402	Тээвэр, шатахуун	1,852,900.00	525,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,614,078.80	5,129,360.61
210404	Ном, хэвлэл	33,000.00	9,900,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	820,000.00	820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,397,300.00	9,380,720.00
2105	Нормативт зардал	1,645,100.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,645,100.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,087,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	230,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	857,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,986,550.00	42,582,185.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,633,650.00	34,369,285.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	95,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,500.00	97,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,660,000.00	5,520,000.00

Хүүхдийн төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,614,392.76	19,601,301.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,728,565.00	2,667,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	72,628,565.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	2,667,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,885,827.76	16,933,501.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,134,407.76	16,904,546.97
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	5,751,420.00	28,955.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,721,251.00	33,103,591.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,721,251.00	33,103,591.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,721,251.00	33,103,591.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,721,251.00	33,103,591.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,721,251.00	33,103,591.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(20,721,251.00)	(33,103,591.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	610,662,500.00	593,757,953.03	16,904,546.97	97.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	610,662,500.00	593,757,953.03	16,904,546.97	97.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	609,594,700.00	592,690,153.03	16,904,546.97	97.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	384,335,000.00	370,377,391.00	13,957,609.00	96.4
210101	Үндсэн цалин	259,144,200.00	283,175,912.00	(24,031,712.00)	109.3
210102	Нэмэгдэл	84,870,800.00	67,025,879.00	17,844,921.00	79.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,320,000.00	20,175,600.00	20,144,400.00	50.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,885,300.00	48,959,200.42	2,926,099.58	94.4
210201	Тэтгэврийн даатгал	36,511,800.00	34,507,467.12	2,004,332.88	94.5
210202	Тэтгэмжийн даатгал	3,843,400.00	3,841,930.36	1,469.64	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,074,700.00	2,955,943.42	118,756.58	96.1
210204	Ажилгүйдлийн даатгал	768,700.00	695,806.28	72,893.72	90.5
210205	Эрүүл мэндийн даатгал	7,686,700.00	6,958,053.24	728,646.76	90.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,047,700.00	137,047,700.00	00.00	100.0
210304	Байрны түрээс	137,047,700.00	137,047,700.00	00.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	31,681,800.00	31,660,961.61	20,838.39	99.9
210401	Бичиг хэрэг	2,123,600.00	2,123,570.00	30.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,235,000.00	525,000.00	710,000.00	42.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,902,000.00	5,129,360.61	(227,360.61)	104.6
210404	Ном, хэвлэл	17,988,400.00	17,982,911.00	5,489.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	820,000.00	820,000.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,612,800.00	5,080,120.00	(467,320.00)	110.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,644,900.00	4,644,900.00	00.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	410,000.00	410,000.00	00.00	100.0

Хүүхдийн төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	95,400.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,500.00	97,500.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,042,000.00	2,042,000.00	00.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,067,800.00	1,067,800.00	00.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,067,800.00	1,067,800.00	00.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,067,800.00	1,067,800.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	610,662,500.00	593,757,953.03	16,904,546.97	97.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	610,662,500.00	593,757,953.03	16,904,546.97	97.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	610,662,500.00	593,757,953.03	16,904,546.97	97.2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32	32		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	23	23		
620003	Үйлчлэх ажилтан	8	8		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		70,208,120.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		70,208,120.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		68,579,165.00
2104	Хангамж, бараа материалын зардал		15,074,100.00
210401	Бичиг хэрэг		233,500.00
210404	Ном, хэвлэл		10,290,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,550,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		13,968,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		7,481,890.00
210602	Тавилга		5,629,990.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		857,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		39,536,185.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		35,558,185.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		3,478,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,628,955.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,628,955.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,600,000.00
	Төвлөрүүлэх шилжүүлэг		28,955.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		70,208,120.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		70,208,120.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		30,597,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		30,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		9,110,600.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад бараа материал худалдан авах, ажил үйлчилгээний төлбөрийг И баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 18-ны хооронд Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн аудитор Ч.Оюундулам, аудиторов туслах Б.Туяажаргал нар гүйцэтгэж, хяналтыг захирал Ч.Энхчимэг, чанарын хяналтын менежер Д.Мядагмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүүхдийн төв номын сан 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүүхдийн төв номын сангийн эрхэм зорилго нь Хүүхэд залуучуудад төрөл бүрийн ном, хэвлэл, мэдээллээр үйлчлэхэд оршино.

Тус байгууллагын зорилт нь Монгол улсын хүүхэд залуучуудад хүн төрөлхтний оюуны цаглашгүй ариун өв сангаас хүртээж ирээдүйдээ итгэлтэй, хүнлэг ариун ёс суртахуунтай, даяарчлалын эрин зуунд хөл нийлүүлэн алхах өргөн баян мэдлэг боловсролтой иргэн болгон төлөвшихөд чиглэгдсэн, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэхэд оршино. Үүнд:

- Хүүхэд, залуучуудад ном, бусад мэдээллээр үйлчлэх,
- Сан хөмрөгийг шинэчлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах,
- Номын сангийн үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх, шинэчлэл хийх,
- Хүүхдийн ном, хэвлэлийн архивын болон мэдээллийн сан бүрдүүлэх,
- ЕБС-ын номын санг мэргэжил-арга зүйн удирдлагаар хангах,
- Хүүхдэд зориулсан хэвлэлийн бүтээгдэхүүнийг бүрэн болон хэсэгчилсэн цахим хэлбэрт оруулж цахим уншлагын үйлчилгээг үзүүлэх,
- Хүүхэд залууст мэдээллийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх зорилгоор зөөврийн номын сан болон ном солилцох үйлчилгээ үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2021 онд шилэн дансанд хийсэн дотоод аудитаар 19 нэр төрлийн 149 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож, нийт 3 удаагийн 15.2 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна. Дотоод аудитын дүнгээр тус байгууллагад Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт 95.3 хувьтай гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүүхдийн төв номын сан 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 731,673.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,316.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүүхдийн төв номын сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 67,132.4 мянган төгрөгөөр буюу 12 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	6,361.4	0.2	(6,361.2)
Бараа материал	13,158.0	30,182.6	17,024.6
Үндсэн хөрөнгө	615,561.2	682,693.6	67,132.4
Нийт хөрөнгө	635,080.6	712,876.4	77,795.8
Засгийн газрын хувь оролцоо	635,080.6	712,876.4	77,795.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	635,080.6	712,876.4	77,795.8

Авлага дансны үлдэгдэл 0.2 мянган төгрөг болж, 6,361.2 мянган төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлага буурснаас шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 30,182.6 мянган төгрөг болж, 17,024.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 34,078.6 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 14,354.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй авч, 31,408.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 682,693.6 мянган төгрөг болж, 67,132.4 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуй нэгж болон хувь хүмүүсээс 6,399.7 мянга, Тайванаас 5,554.9 мянга, Монгол шуудан ХХК-аас 49.8 мянган төгрөгийн ном, Солонгос улсаас “Баярлалаа бяцхан номын сан” төслийн хүрээнд ном ариутгах төхөөрөмж 27,616.5 мянган, Соёлын яамны хөрөнгө оруулалтын газраас 1,654.4 мянган төгрөгийн зөөврийн компьютер, нийт 41,275.3 мянган төгрөгийн хөрөнгө хандиваар, урсгал төсвийн худалдан авалтаар 33,103.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан авснаас шалтгаалжээ. Тайлант оны элэгдлийн зардал 7,246.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 712,876.4 мянган төгрөг болж 77,795.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хүүхдийн төв номын сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 872.9 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 45,050.1 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажлын зардал, хангамж бараа материалын зардал, бусад урсгал зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төслийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,037,784.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,037,784.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 427,122.1 мянган төгрөгөөр бууруулж 610,662.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны талбайн түрээсийн зардлын м2 тутмын үнэлгээг 2002 онд тогтоосон 5.0 мянган төгрөгөөр тооцогдож ирснийг өнөөгийн жишиг үнэлгээгээр тооцож нэмэгдүүлснийг, хүүхдийн ариун цэврийн өрөөний засвар, аюулгүй байдлыг сайжруулах урсгал засварын зардал, хүүхдийн номын фонд зэргийг нэмэгдүүлэн төлөвлөснийг бууруулсантай холбоотой.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 610,662.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 610,662.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 610,662.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 593,757.9 мянган төгрөгийг зарцуулж 16,904.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 593,757.9 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 13,975.6 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын зардлыг 2,926.1 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 20.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 30,597.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 30,500.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 9,110.6 мянга, нийт 70,208.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалд 15,074.1 мянга, эд хогшил худалдан авахад 13,968.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 39,536.2 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 1,600.0 мянга, нийт 70,179.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 28.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хүүхдийн төв номын сан нь 32 ажилтантай, захиргаа аж ахуйн хэлтэс, мэдээлэл технологи арга зүйн хэлтэс, уншлага үйлчилгээний хэлтэс гэсэн 3 хэлтсээс бүрддэг.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 3 хөтөлбөр, 7 арга хэмжээний хэрэгжилт 100 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулсан төсвийн гүйцэтгэл 97.2 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Хүүхдийн төв номын сангийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 19 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд шилэн дансны цахим мэдээллийн системд хуулийн дагуу байршуулах 149 мэдээллээс 146 мэдээллийг байршуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 1, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг 1, нийт 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтыг хэрэгжүүлж 17,314.6 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 17,082.1 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илрүүлснээс алдааг залруулж өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 11,420.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 153.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг биелүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянгантөгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	1	11,420.6	1	11,420.6			100.0
Зөвлөмж	1	153.5	1	153.5			100.0
Нийт дүн	2	11,574.1	2	11,574.1			100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үйл ажиллагааны орлоготой холбоотойгоор цахим төлбөрийн баримтын бүрдэл, ажилчдын цалин хөлсний тооцооллыг дахин хянах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 22,601.1 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 22,382.1 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 219.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 1 алдаа зөрчлийн дүн 219.0 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 7,316.7 мянган төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Төлбөрийн цахим баримтын системд орлого, зарлагын баримтуудтай тулгахад 5,300.0 мянган төгрөгийн дутуу цахим баримтыг нөхөж шивсэн;
- Шилэн дансны цахим хуудсанд ном хэвлэлтийн 9,900.0 мянга, номын хавчуурга болон хаягжуулалтын 5,267.3 мянга, нийт 15,167.3 мянган төгрөгийн худалдан авалтын дүнг дутуу байсныг нөхөж мэдээлсэн;
- Хандиваар авсан 1,914.8 мянган төгрөгийн давхардуулан бүртгэсэн номыг балансаас хасаж залруулсан.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Ибаримттай холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт:*

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 219.0 мянган төгрөгийн орлогыг цахим и-баримтын системд бүртгээгүй байгаа нь Нэмэгдсэн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно” гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материал худалдан авах, ажил үйлчилгээний төлбөрийг И баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Хүүхдийн төв номын сан	АХГ-2022/208/НА-СТА-ТШЗ	Үндсэн үйл ажиллагааны хүрээнд граш болон шилэн хорго түрээслүүлсний орлогыг цахим и-баримтын системд бүртгээгүй зөрчил илэрсэн.	Цахим баримтын ибаримт системд нөхөн шивүүлэв.	1	5,300.0	1	5,300.0						
2	Хүүхдийн төв номын сан	АХГ-2022/208/НА-СТА-ТШЗ	Хандиваар авсан номыг давхардуулан бүртгэсэн зөрчил илэрсэн.	Давхардуулан бүртгэсэн үндсэн хөрөнгийг хасалт хийлгэв.	1	1,914.8	1	1,914.8						
3	Хүүхдийн төв номын сан	АХГ-2022/208/НА-СТА-ТШЗ	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын гүйлгээг мэдээлээгүй зөрчил илэрсэн.	www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг нөхөж байршуулав.	1	15,167.3	1	15,167.3						

Хүүхдийн төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	Хүүхдийн төв номын сан	АХГ-2022/208/НА-СТА-ТШЗ	Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг и-баримтын системд дутуу бүртгэсэн байна	Бүх үйл ажиллагааны орлого болон худалдан авалтыг ибаримтжуулж байх.	1	219.0							1	219.0
ДҮН					4	22,601.1	3	22,382.1					1	219.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Хүүхдийн төв номын сан	АХГ-2022/208/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах;	1								1	
ДҮН					1								1	0
НИЙТ ДҮН					5	22,601.1	3	22,382.1					1	0
													1	219.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 243/А0150458
АХГ-2022/208/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд байгууллагын шилэн дансны цахим мэдээллийн системд хуулийн дагуу байршуулах 149 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "Мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүүхдийн төв номын сангийн дарга С.Хүрэлбаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц НАРАНЧИМЭГ
С НАЦАГДОРЖ
Ч ЭНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264233

110.00.10.2010xlog_KhengUdon_StampAgar20220227_Audit_2_Cover-239.docx

0010800742

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines, providing a template for writing.